

ШИНЭСТ ХК –ийн 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Шинэст ХК нь 2020 оны эхний хагас жил борлуулалтаа нэмэгдүүлж, маркетингаа идэвхижүүлэхээр дараах ажилуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа танилцуулья.

Үүнд:

Бид 2019 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн Мэйжор Дриллинг Монгол ХХК-д үйлдвэрийн болон оффисын барилгыг бүрэн түрээслэж эхлээд жил болж байна. СХД, 32-р хороо, Хуучин Авто худалдааны төвийн ойролцоо байрлах 864м² талбай бүхий сэндвичэн барилгыг түрээслэж зарим тоног төхөөрөмжөө ажилуулж эхлээд байна. Мөн ХУД, 3-р хороонд байрлах Мишээл Мега Молл ХХК-н талбайд байрлах контейнерыг түрээсэлж бэлэн бүтээгдэхүүнүүдээ тэндээсээ борлуулалт хийж байна. Мишээл Мега Молл ХХК-д манай showroom байгаа тул тэндээсээ борлуулалт хийхэд илүү ойр, хялбар.

Зарим модон бэлдэц тоног төхөөрөмжөө БЗД-ийн Амгалан гаалийн хяналтын бүсийн хажууд сэндивч түрээслэн хадаглаж байгаа.

Одоогоор бид дахин үйлдвэр барих эсэх, цаашид өөр том обект газар түрээслэх зэрэг асуудлыг судлаж байна. Дэлхийн нийтэд гаралт байгаа цар тахал COVID –с үүдэн зах зээл эргэлт муу удааширлалтай байгаа тул бид судалгаанд түвшиннд ажилаа хийж байна.

Үйл ажиллагаа:

1. Хаан банкнаас зээлсэн богино хугацаат зээл авж үйлдвэрийн хашаа болон дотор зам талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгээд байна.
2. ХХБ-наас авсан 500,000,000 төгрөгийн бизнесийн зээлийн эргэн төлөлтөө төлөөд явж байна..
3. Мишээл Мега Молл ХХК-д павильон түрээсэлж, наамал дүнзэн хаусын материалаар бүрэн тохижуулан үйл ажиллагаагаа одоогийн байдалаар тэндээс үйл ажиллагаа борлуулалтаа явуулан ажиллаж байна.
4. Эрсдлээс урьдчилан сэргийлж Тэнгэр Даатгал ХХК-д үйлдвэрийн болон оффисын барилгуудаа дараах эрсдлээс хамгаалж даатгалын гэрээгээ сунгаж даатгууллаа.
 - Гал түймэр, дэлбэрэлт
 - Байгалийн гамшигийн бүх эрсдлүүд
 - Ус чийгний нөлөөллийн эрсдэл

- Цахилгаан эрчим хүчний эрсдэл
- Цонхны шилний хохирол

Дүгнэлт:

2020 оны эхний хагаст Шинэст ХК-ийн үйл ажиллагаанд тодорхой хэлбэрээр ахиц дэвшил гарсан боловч дараах үндсэн зорилгууддаа хүрч ажиллаж чадаагүй.

Үүнд:

- Төлөвлөсөн борлуулалтын орлого биелэгдээгүй
- Үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- ажилчидын цалин хөлс, тэтгэмжийг нэмэх
- гадна болон үйлдвэрийн доторх сантехникийн шугамын шинэчлэл
-

Шалтгаан нь:

Манай борлуулалт жилээс жилд улам багассаар байна. Иймд бид бүтээгдэхүүнийхээ чанарт илүү анхаарч эхэлсэн. Мөн маркетинг, сурталчилгаа сайн хийж, борлуулалтын сувгаа нэмхээр ажилласаар ирлээ.

Гэвч манай борлуулалтын орлого байгууллагын сарын зардлыг дөнгөж нөхөхүйц, зарим өвлийн саруудад зээл болон бусад эх үүсвэрээр нөхөж байгаа нь үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах дорвитой шийдэлийг эрэлхийлсээр байна.

Компанийн үйл ажиллагааны чиглэлийн талаар бид сайн бodoх хэрэгтэй байна. Цаашид үнэхээр модон бэлдэцээ хийхүү нэг бол өөр чиглэлрүү орох эсэх талаар сайн судлаж байж шийдвэрээ гаргах нь чухал гэж бодож байна. Нэг бол үйлдвэр дахин барих, түрээслэх зэрэг асуудлаа шийдэх, ямар бүтээгдэхүүн гаргавал илүү бүтээмжтэй зэрэг талаар сайтар судлах нь зүйтэй.

Компанийн үйл ажиллагааны чиглэлийн талаар дор бүрнээ сайн бodoх хэрэгтэй. Цаашид модон бэлдэцийн үйлдвэрлэлээ үргэлжлүүлээд явна гэхээр миний хувьд бол тоохиромжгүй санагдаж байна. Сүүлийн жилүүдийн тайлан балансаас харахад зээлээс зээлийн хооронд, өнөө маргаашаа аргацаасан байдалтай яваад удлаа. Одоо томоохон өөрчлөлт хийх цаг нь болсон гэж үзэж байна.

Энэ талаар дахин хуралдсан нь дээр гэж үзэж байна. Одоо энэ том үйлдвэрийг хэрхэн яаж зардал төсөв багатай үйл ажиллагаа явуулах вэ гэдэг нь чухал.

Хэлэлцэх асуудлаа шийдвэрлэлээ. 13 цаг болж байна. Хурлыг ингээд хааяя. Баярлалаа.

Хурлын тэргүүлэгч:



/Э.Болор /

Нарийн бичгийн дарга

/Т.Оюунтүлхүүр/